



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 191

Улаанбаатар хот

Хөрөнгө хүлээн авч бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.1, дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс 2021 оны 06/3111 дүгээр албан бичгээр ирүүлсэн шаардлагын дагуу нийт 4,475,440,500.00 (дөрвөн тэрбум дөрвөн зуун далан таван сая дөрвөн зуун дөчин мянга таван зуун) төгрөгийн хөрөнгө бүхий “Монголиан Смелтинг Корпорейшн” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын Лондон хотын “Unit 4, Quebec wharf, 315 kingsland road, hackney, London, E8 4DJ” тоот хаягт байрлах 110 м.кв талбай бүхий орон сууцны барилгын хамт өмчлөгч болох иргэн З.Ганбаатарын сайн дураараа шилжүүлэн өгөх хүсэлтийг үндэслэн төрд учруулсан хохиролд тооцон төрийн өмчид хүлээн авч “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газарт эзэмшүүлэн, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. “Монголиан Смелтинг Корпорейшн” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг өмчлөх эрхийг шилжүүлэн авч улсын бүртгэлд бүртгүүлэх;

2.2. Үл хөдлөх хөрөнгийг хүлээн авч өмчлөх эрхийг шилжүүлэх, тухайн улсын хууль тогтоомжид нийцүүлэн өмчлөх эрхийг баталгаажуулах, ажлыг зохион байгуулах;

2.3. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу хүлээлцэх, нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга А.Ариунболдод үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
132001435